



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/230

Улаанбаатар хот

Томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны "Журам батлах тухай" 98 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам"-ын 4.5 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугаар тушаалаар батлагдсан "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээ тогтоох тухай" журмын 6.3 дахь заалт, төвийн Ерөнхий захирлын 2017 оны А/183 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөө орон нутагт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах, төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2012-2016 онд улсын төсвийн санхүүжилтээр хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн төрийн сангийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийх ажлын удирдамж"-ийг нэгдүгээр, "Орон нутагт ажиллах албан хаагчдын нэрс, хуваарь"-ийг хоёрдугаар, Албан томилолтод шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гуравдугаар хавсралтад дурдагдсан зардлыг төсвийн дотоод албан томилолтын зардлаас тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Мэргэжилтэн Х.Уянга, О.Баярсайхан нарыг томилолтоор ажиллах хугацаанд албан ажил үүргийг нь зохицуулж ажиллахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

4. Ажлыг холбогдох журам, удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж тайланг ажлын гурав хоногт багтаан танилцуулахыг мэргэжилтэн Х.Уянга, О.Баярсайхан нарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА



2017 оны 12 сарын 14 өдрийн

Ерөнхий захирлын
дугаар тушаалын
Нэгдүгээр хавсралт

**ХӨДӨӨ ОРОН НУТАГТ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ АВАХ, ТӨГСӨЛТИЙН ДАРААХ ҮНДСЭН БОЛОН
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТАД 2012-2016 ОНД УЛСЫН ТӨСВИЙН
САНХҮҮЖИЛТЭЭР ХАМРАГДСАН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ТӨРИЙН
САНГИЙН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ХИЙХ, АЖЛЫН УДИРДАМЖ**

2017-12-07

Үндэслэл:

Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Журам батлах тухай” 98 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ын 4.5-д заасны дагуу хөдөө орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүдээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах, Монгол улсын эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугаар тушаалаар батлагдсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээ тогтох тухай” журмын 6.3 дахь хэрэгжилтэд хяналт хийх

Зорилго:

Хөдөө орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүдээс зөвшөөрлийн шалгалт авах, төрийн сангийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийх үйл ажиллагааг зохион байгуулах

Гүйцэтгэх ажил:

1. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Журам батлах тухай” 98 дугаар тушаалын 5.4. дэх заалтын дагуу Дархан, Хөвсгөл аймгийн эмнэлгийн мэргэжилтнүүдээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах
2. Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2012-2016 онд улсын төсвийн санхүүжилтээр Дархан, Хөвсгөл аймгаас хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний төрийн сангийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийх
3. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Журам батлах тухай” 98 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”, Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2013 оны 491/А/472 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”, Монгол улсын эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугаар тушаалаар батлагдсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” журмыг танилцуулах, сурталчлах

Байршил: Дархан, Хөвсгөл аймгийн төвд

Хугацаа:

2017 оны 12 дугаар сарын 15-18

Үр дүн:

1. Дархан, Хөвсгөл аймгийн эмнэлгийн мэргэжилтнүүдээс зөвшөөрлийн шалгалтыг "Журам батлах тухай" Эрүүл мэнд, спортын сайдын 98 дугаар тушаалын 4.5 дэх заалтын дагуу зохион байгуулна.
2. Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2012-2016 онд улсын төсвийн санхүүжилтээр Дархан, Хөвсгөл аймгаас хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний төрийн сангийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийсэн байна.
3. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны "Журам батлах тухай" 98 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам", Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/337 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам", Монгол улсын эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугаар тушаалаар батлагдсан "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээ тогтоох тухай" журмыг танилцуулж сурталчилсан байна.


2017 оны 12 сарын 14 өдрийн 1/3 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ОРОН НУТАГТ АЖИЛЛАХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС, ХУВААРЬ

№	Албан тушаал	Нэр	Хаана	хугацаа
1	Эрүүл мэндийн хөгжлийн хүний нөөцийн мэдээний сан хариуцсан мэргэжилтэн	Х.Уянга	Дархан	2017.12.18-19
2	Эрүүл мэндийн хөгжлийн тасралтгүй сургалтын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	О.Баярсайхан	Хөвсгөл	2017.12.16-18

Ерөнхий захирлын
2017 оны 2 сарын 14 өдрийн 11 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт



АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Явах чиглэл:

УЛААНБААТАР- ДАРХАН-УЛААНБААТАР

Д/д	Албан тушаал	Тооцох зам хоног	Хүний тоо	Албан томилолтын хугацаа	Нийт зам хоногийн зардал
1	Зам хоног /хоол/	16,000	1	2	32,000
2	Зочид буудал	35,000	1	1	35,000
3	Нийтийн тээвэр	20,000	1		40,000
	ДҮН				107,000

Явах чиглэл:

УЛААНБААТАР- ХӨВСГӨЛ-УЛААНБААТАР

Д/д	Албан тушаал	Тооцох зам хоног	Хүний тоо	Албан томилолтын хугацаа	Нийт зам хоногийн зардал
1	Зам хоног /Аймагт/	14,000	1	3	42,000
2	Зочид буудал	35,000	1	2	70,000
3	Нийтийн тээвэр	33,000	1		66,000
	ДҮН				178,000

НИЙТ ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ

285,000

Хянасан: Ахлах нягтлан бодогч

Боловсруулсан: Нягтлан бодогч

Д.Гантуяа

С.Лхагвасүрэн